



ТӨВ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 25 өдөр

Дугаар А/492

Зуунмод

“Аюулыг авдарлая”
уралдаан зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.9, 9.3.10 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хүрээлэн буй орчны бохирдлыг багасгах зорилгоор Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо, Бөмбөрцөгийн сүмбэ ТББ-ын санаачлан хэрэгжүүлж байгаа “Аюулыг авдарлая” тамхины иш түүж савлах, тамхины уут урлах уралдааныг зарласугай.

2. “Аюулыг авдарлая” уралдааны удирдамжийг нэгдүгээр, зохион байгуулах, дүгнэх ажлын хэсгийг хоёрдугаар, урамшууллын зардлыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Уралдааныг сумын хэмжээнд зохион байгуулан, үр дүнг тооцох, сумын нийт дүнгээр аймгийн хэмжээнд өсөлдөхийг сумдын Засаг дарга нарт үүрэг болсугай.

4. Уралдааны урамшуулалд олгох зардлыг аймгийн байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 1,980,000 (нэг сая есөн зуун наян мянга) төгрөгийг санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ю.Бямбацогт)-д зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Ж.Даш-яйчил)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

Аймгийн Засаг даргын 2022 оны 08 дүгээр сарын 25-ны өдрийн А/492 дүгээр захирамжийн 3 дугаар хавсралт



ШАГНАЛ УРАМШУУЛЛЫН ЗАРДАЛ



1. Хамгийн их тамхны иш түүсэн шилдэг баг

Байр эзлэх	Батламж	Мөнгөн урамшуулал	Гарын бэлэг
1	30,000	300,000 ✓	100,000
2	30,000	200,000 ✓	100,000
3	30,000	100,000 ✓	100,000
Дүн	90,000	600,000	300,000
Нийт дүн			990,000


2. Тамхины уут урласан шилдэг баг

Байр эзлэх	Батламж	Мөнгөн урамшуулал	Гарын бэлэг
1	30,000	300,000 ✓	100,000
2	30,000	200,000 ✓	100,000
3	30,000	100,000	100,000
Дүн	90,000	600,000	300,000
Нийт дүн			990,000

ХЯНАСАН:

БАЙГАЛЬ, ОЧИН АЯЛАЛ ЖУУЧЛАЛЫН
ГАЗРЫН ДАРГА  Ж.ДАШ-ЯЙЧИЛ
САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН  Ч.ЦЭЦЭГСҮРЭН

ТӨСӨВ ХИЙСЭН:

БАЙГАЛЬ, ОЧИН АЯЛАЛ ЖУУЧЛАЛЫН ГАЗРЫН
МЭРГЭЖИЛТЭН  М.ЦЭЭПИЛ